



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/10

Мандалговь

Байгууллагын гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийг дэмжих зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6, 7 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.3.3-12.3.5 дахь заалт, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаал “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 5.3 дахь заалт, “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл”-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолыг аймгийн Засаг даргын 2015 оны 10 сарын 27-ны өдрийн А/418 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Мэдээллийн сан, байгаль орчны төлөв байдал, сургалт сурталчилгаа, төсөл хөтөлбөр, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Сантехникч, жижүүр

Нарийн бичгийн дарга: Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2.Холбогдох хууль, дүрэм, журам, хөтөлбөрийг мөрдлөг болгон төрөл бүрийн арга хэмжээг үйл ажиллагаандаа идэвх санаачилгатай хэрэгжүүлж, гэр бүл, хүүхэд, залуучуудын эрх, хөгжил, оролцоог хангахтай холбоотой асуудлаар санал, санаачилга гаргаж ажиллахыг зөвлөлд, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн даргад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА

